

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,  
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**  
/2022 оны жилийн эцэс/

2023.01.05

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
<b>Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх</b>						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	20	78	<p><b>Төрийн албаны зөвлөлийн сургалт:</b> Төрийн албаны зөвлөлийн 4:7:10 арга зүйн 35 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 185 албан хаагч, Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр, Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, Томуугийн үндэсний зөвлөгөөн, Хүний эрх ба жендэр сургалтад, Сонгуулийн сургагч багш сургалтад, Улсын байцаагчийн эрх олгох сургалт, Говийн бүсийн уул уурхайн чуулга, уулзалт, Газар зүйн заалтын ач холбогдол зэрэг сургалт, зөвлөгөөнд нийт 10 албан хаагч хамрагдсан.</p> <p><b>Удирдлагын академийн сургалт:</b> Байгууллагын ёс зүйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах 2 удаагийн сургалтад 14, Төрийн байгууллага дахь харилцааны маркетинг сургалтад 2, Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчлэл сургалтад 3, Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн болон эрсдэлийн шинжилгээ сургалтад 3, Орон нутгийн хөгжлийн стратеги, бодлогын төлөвлөлт, зохицуулалт сургалтад 2, төрийн жинхэнэ албанд анх томилогдсон иргэдийг мэргэшүүлэх багц сургалтад 2, Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 10, Мэргэшүүлэх ахлах түшмэлийн багц сургалтад 4, Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулсан.</p> <p><b>Туршлага судлах арга хэмжээ:</b> Улаанбаатар хотын төлөвлөлт, ногоон байгууламж, ландшафт, шинжлэх ухаан, инновацийг хөгжүүлж байгаа үйл ажиллагаатай 24 албан хаагч танилцаж туршлага судалсан. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 5 гишүүн Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаатай танилцан туршлага судалсан.</p> <p><b>Байгууллагын дотоод сургалт, бусад сургалт:</b> Монгол бичгийн анхан шатны 15 удаагийн сургалтад давхардсан</p>
		Үүнэ эс	Ажлын байран дахь сургалт	15	55	
			Мэргэшүүлэх сургалт	5	12	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	2	
			Бусад	-	7	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	51	51	
		Үүнэ эс	Эмэгтэй албан хаагч	30	33	
			Эрэгтэй албан хаагч	16	18	
			Удирдах албан тушаалтан	9	9	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	35	42	

		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	100%	тоогоор 230 албан хаагч, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн сургалтад 25, Ард түмэнд үйлчлэх зарчим ба авлига, сонирхлын зөрчил сургалтад 30, Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх журам сургалтад 23, Шинэ зууны манлайлал ба эмэгтэйчүүд сургалтад 32, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам сургалтад 28 албан хаагч хамрагдсан байна. Мөн Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтад 12 албан хаагч, Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх М1, М2, М3-ын сургалтад 11 албан хаагчийг хамруулсан. <b>Хүрсэн түвшин:</b> Нийт 78 удаагийн сургалт, 2 удаагийн туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 661 албан хаагч буюу 51 төрийн албан хаагчийг хамруулсан нь нийт албан хаагчийн 100 хувийг сургаж, чадавхжуулсан байна.
<b>Хэрэгжилт</b>						<b>100 хувь</b>
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	1	2	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Гадаад хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах уралдаан, тэмцээн, бусад арга хэмжээнд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийг оролцоход дэмжлэг үзүүлэхээр 11 сая төгрөгийг төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажилласан. Тус хөтөлбөрийн хүрээнд Бүгд Найрамдах Сингапур улсын "Темасек" олон улсын сантай хамтран Сингапур улсын Төрийн албаны коллежид зохион байгуулж буй "Төрийн албан тушаалтны чадавхыг бэхжүүлэх сургалт"-д аймгийн Засаг даргын Тамгын газрын даргыг хамруулсан. 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр "NEAR 2022"-Олон улсын форумыг БНСУ-ын Гёнсанбүг мужад "6 дахь аж үйлдвэрийн хөгжлийг Зүүн хойд Азийн хөдөө тосгон, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний аж үйлдвэрийн ирээдүйн хөгжлийн стратегитай уялдуулах нь" сэдвээр зохион байгуулсан бөгөөд тус форумд орон нутгийг төлөөлөн төрийн байгууллагын 5 албан хаагч хамрагдсан. БНХАУ-ын Жяньсу мужийн Уши хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд "Бүс нутгийн хамтын ажиллагааны 20 дахь удаагийн форум"-д аймгийн Засаг дарга цахимаар оролцсон. <b>Хүрсэн түвшин:</b> Тайлант хугацаанд 7 албан хаагчийг гадаад сургалт, семинарт хамруулсан бөгөөд төрийн захиргааны албан хаагчдын 14.9 хувийг хамруулсан байна.
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	2-оос дээш	6	
		Үүнэ эс	Эмэгтэй албан хаагч	1	2	
			Эрэгтэй албан хаагч	1	4	
			Удирдах албан тушаалтан	1	2	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	1	4	
2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	14.9 хувь			
<b>Хэрэгжилт</b>						<b>96.35 хувь</b>

3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	12 албан хаагчид 5.1 сая төгрөг олгосон	Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтанд 12, Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалтад 4 албан хаагч, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагчийг нийт 5.1 сая төгрөгийн төлбөртэйгөөр хамруулсан байна.
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	13.8	Аймгийн ЗДТГазарт 2022 онд 59 орон тоо батлагдсанаас жилийн эцсийн байдлаар 7 албан хаагч чөлөөлөгдөж, 19 албан хаагч шинээр томилогдсоноор 2021 онд 50 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байсан бол 2022 онд 51 албан хаагч ажилласан байна. Шилжилт хөдөлгөөнийг дараах томъёогоор тооцов.  Шилжилт хөдөлгөөн= $\frac{\text{Чөлөөлөгдсөн албан хаагчдын тоо}}{\text{Хугацааны эхэнд ажиллаж байсан АХ+хугацааны төгсгөлд ажиллаж байсан АХ}} \cdot 100$
<b>Хэрэгжилт</b>					<b>100 хувь</b>	
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	Батлагдсан төсвийн дагуу	Байгууллагын нийт төсөв 2,651,937,600	2022 онд нийт 59 орон тоо батлагдсанаас 51 албан хаагчдын цалин хөлсөнд 730,487,414 төгрөг, 10 албан хаагчид 6 сая төгрөгийн шагнал, 51 албан хаагчид 49,464,786 төгрөгийн урамшуулал, нийт 785,952,200 төгрөгийн цалин хөлс, шагнал, урамшуулал олгосон нь байгууллагын нийт төсвийн 30 хувийг цалин хөлс, шагнал, урамшуулалд зарцуулсан байна.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	3.0	5.0	2022 онд байгууллагын дотоод журмын дагуу өдрийн хоол, унааны зардлыг 5000 төгрөгөөр тооцон 1-12 сарын хоол унааны зардалд 41 690 206 төгрөгийг 51 албан хаагчдад олгосон.
<b>Хэрэгжилт</b>					<b>100 хувь</b>	
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	85.0	Байгууллагын уур амьсгал, таатай орчны сэтгэл ханамжийн судалгааг 2022 онд 1 удаа авсан. Судалгаанд нийт 53 албан хаагчаас 39 албан хаагч буюу 73.5 хувь нь хамрагдсан байна. Судалгааны дүнгээс харахад 85.0 хувь сайн гэж үнэлсэн нь өмнөх оноос 5 хувиар өссөн. Сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Албан хаагчдын ажлын байрны орчин нөхцлийг сайжруулахад анхаарч байгууллагын урсгал засварыг 11 сая төгрөгөөр хийж байгууллагын нэгдүгээр давхар болон ОО-ын өрөөг бүрэн засварласан. 16 албан хаагчийн компьютер, принтерийг шинэчилсэн. Албан хаагчдын гүйцэтгэлийн үр дүнг Засгийн газрын 2020 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

						боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу улирал бүр дүгнэж, хагас, бүтэн жилээр үнэлэн урамшуулал олгож байна.
<b>Хэрэгжилт</b>						<b>100 хувь</b>
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	2	Эрт илрүүлэгийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо болон "Хавдаргүй Монгол эмэгтэй" аяны хүрээнд 2 удаагийн үзлэгт 45 албан хаагчийг хамруулсанаар нийт албан хаагчдын 88.2 хувийг оношлуулсан байна.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	88.2	
<b>Хэрэгжилт</b>						<b>100 хувь</b>
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 81 561 700	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчид тэтгэмж олгох, тусламж үзүүлэх, нөхөн төлбөр олгох гэж заасны дагуу нийт 81,060.322 төгрөгийг давхардсан тоогоор 43 албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан. Үүнд: Нэг удаагийн буцалтгүй тусламж 49,856.950 төгрөг. (23 албан хаагч) Шагнал 6.0 сая төгрөг. (10 албан хаагч) Дэмжлэг 8,640.000 төгрөг. (10 албан хаагч)
<b>Хэрэгжилт</b>						<b>99.3 хувь</b>
<b>Дундаж хэрэгжилт</b>						<b>98.95 хувь</b>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР